

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

Мод, сөөгний суулгацыг бойжуулах. Ерөнхий шаардлага	MNS 6254 : 2011
Growing seedlings of trees and shrubs. General requirement	

Стандарчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 04-р сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

1. Зорилго

Бойжуулсан талбайд ургуулсан суулгацыг хот, суурин газрыг цэцэрлэгжүүлэх, тариалангийн талбайд зурвас байгуулах, хөрсийг элэгдлээс хамгаалах, гуу жалга, эрэг ганга, элсийг бэхлэх зэрэг ойжуулалтын ажилд хэрэглэнэ.

2. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь төрөл бүрийн мод, сөөгний тарьцыг бойжуулгын талбайд шилжүүлэн суулгаж, стандартын суулгац авахад хамаарна.

3. Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас иш татаж хэрэглэнэ.

- MNS 6139 : 2010, Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага,
- MNS 6141 : 2010, Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага,
- MNS 6140 : 2010, Мод, сөөгний тарьц. Техникийн шаардлага,
- ГОСТ 24835 : 81, Мод, сөөгний суулгац. Техникийн шаардлага,
- ГОСТ 24909 : 81, Чимэглэлийн навчит модны суулгац. Техникийн шаардлага,
- ГОСТ 26869:86, Чимэглэлийн сөөгний суулгац. Техникийн шаардлага.

4. Нэр томъёо, тодорхойлолт

4.1

Тарьц

Мод үржүүлгийн газарт үр болон мөчрөөр ургуулсан 1-ээс 2 настай модлог ургамал,

4.2

Суулгац

Бойжуулгын талбайд шилжүүлэн суулгаж ургуулсан 2-оос дээш настай модлог ургамал,

4.3

Бойжуулах талбай

Үр болон мөчрөөр үржүүлсэн тарьцыг бойжуулах зориулалтын талбай.

5. Техникийн шаардлага

5.1 Бойжуулах талбайд шилжүүлэн суулгах шилмүүст, навчит мод болон сөөгний тарьц нь MNS 6140 : 2010-ын шаардлага хангасан байна.

5.2 Шилмүүст модны тарьцыг 4 талбайд, навчит модны тарьцыг 3 талбайд сэлгүүлэн шилмүүст модны тарьцыг 3 жилээр, навчит мод болон сөөгний суулгацыг 2 жилээр тус тус бойжуулна.

5.3 Бойжуулах талбайн хөрсийг эртний ба хар уриншаар боловсруулна.

5.4 Бойжуулах талбайд шилжүүлэн суулгах тарьцыг намар навч унасны дараа буюу хавар навч, шилмүүс задрахаас өмнө суулгана.

5.5 Тарьцыг гараар суулгахдаа царилаар 12-аас 15 см өргөн, 30 см гүн нүх гаргахад, 2 дахь хүн тарьцаа нүхэнд хийж, тарьцнаас 10 см зайд царилаа шигтгэн өөрлүүгээ татаж, нүхийг булж нягтруулан дараагийн тарьцыг суулгана.

6. Арчилгаа

6.1 Тарьцыг арчлахдаа эгнээ хооронд трактор ба сийрүүлэгч машиныг ашиглан сийрүүлж, хамгаалалтын зурвас тарилтын даланг гар ажиллагаагаар хог ургамлыг устгана.

6.2 Навчит модны тарьцыг шилжүүлж суулгасны 2 дахь жилээс эхлэн хажуугийн мөчрийг нь 12-оос 15 см-ээс ихгүй байлгаж, суулгацыг хэлбэршүүлэх зорилгоор 2-оос 3 удаа таналтыг хийнэ. Суулгацын өндөр нь стандартын хэмжээнд хүрэхэд таналтыг хийлгүй хажуугийн мөчрүүдийг засч ургуулна.

6.3 Усалгааг бороожуулагч ба шуудуугаар 5-аас 6 дугаар сард 4-өөс доошгүй удаа, 7-оос 9 дүгээр сард 3-аас доошгүй удаа, цэнэг усалгааг хавар 4-р сард, намар газар хөлдөх хүртэл хийнэ.

ТӨГСӨВ.